



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

“Авто замын засвар арчлалтын нэгтгэл”
төрийн өмчит хувьцаат компанийн
дүрмийг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 6, 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор төрийн өмчийн 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийг байгуулсантай холбогдуулан тус компанийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

2. “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг эрх бүхий этгээд томилох хүртэлх хугацаанд гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх Төрийн өмчийн төлөөлөгчөөр Ц.Баяр-Эрдэнэ (Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга)-ийг томилсугай.

3. “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн өмчийн төлөөлөгч Ц.Баяр-Эрдэнэ (Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 08 дугаар сарын 28 -ны
өдрийн 107 дугаар тогтоолын хавсралт

“АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН НЭГТГЭЛ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компани /цаашид “компани” гэх/-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2. “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компани нь Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Автозамын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Компани нь авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4. “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага /ТӨБЗГ/ байна.

1.5. Компани нь орон нутагт аво зам, засвар арчлалтын салбар, нэгжтэй байх бөгөөд тус салбар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

1.6. Компанийн оноосон нэр нь монголоор “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компани, товчилсон нэр нь “АЗЗА нэгтгэл” ТӨХК, англиар “Road Repair and Maintenance” Joint stock company, товчилсон нэр нь “RRM” JSC болно.

1.7. Компани нь Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршино.
Шуудангийн хаяг:
Утас:, Факс, E-mail:

1.8. Компанийн байршил нь түүний гүйцэтгэх удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ

1.9. Компани нь өөрийн тэмдэг, бэлгэдэл /эмблем/-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэж болно.

1.10. Тэмдэг, бэлгэдлийн загварыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

1.11. Компанийн тэмдэгийг компанийн гүйцэтгэх удирдлага, эсвэл компанийн гүйцэтгэх удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшнэ.

1.12. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хувь хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй.

ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. Компанийн үндсэн зорилт нь Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн бэлэн байдлыг ханган ажиллах гэрээг байгуулж, гэрээний үүргийг заалт бүрээр хэрэгжүүлэн ажиллаж, хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээхэд оршино.

2.2. Компани нь үндсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулна:

2.2.1. компани нь олон улс, улсын чанартай авто замын засвар арчлалтын ажил гүйцэтгэгч салбар нэгжүүдийг шуурхай удирдлагаар хангах, хариуцсан авто зам замын байгууламжид үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажлыг шуурхай зохион байгуулах, ашиглалтын бэлэн байдалд байнгын хяналт тавьж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.2. компани нь авто замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэхдээ Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан салбар нэгжийн байршил, холбогдох норм норматив, журмыг мөрдөж ажиллах;

2.2.3. авто замд тогтоосон журмын дагуу үзлэг хийж, арчлалт, засварын ажлыг тогтмол гүйцэтгэх, авто замаар зорчигчдоос зам, замын байгууламжийн эвдрэл гэмтлийн талаар мэдээлэл авч, шуурхай арга хэмжээ авч ажиллах;

2.2.4. улсын чанартай хариуцсан авто замын бүртгэл, мэдээллийн санг хөтөлж, нэгдсэн бүртгэлд оруулах;

2.2.5. хариуцсан авто замын зурвас болон хяналт тавих зурвас газрыг хамгаалах;

2.2.6. авто зам өмчлөгч болон эзэмшигчийг замын ашиглалтын талаархи мэдээллээр тогтмол ханган ажиллах;

2.2.7. гамшиг, ослын улмаас авто замд эвдрэл, гэмтэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатсан үед олон нийтэд мэдээлж, саадыг арилгах арга хэмжээг шуурхай авч ажиллах;

2.2.8. авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай болон тусгай хамгаалалтгүй гинжит дугуйтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавин ажиллах;

2.2.9. улсын чанартай авто замын хөдөлгөөний эрчмийн тооллогыг зохих журмын дагуу зохион байгуулж ажиллах.

2.2.10. хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа.

2.3. Үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

2.4. Компани нь авто замын засвар, арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах шугаман албадын байршил, засвар арчлалтын ажлын нэгж, норм норматив, төсвийн норм, үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн үнэлгээг мөрдөнө.

2.5. Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.6. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу явуулна.

2.7. Компани нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.

ГУРАВ. КОМПАНИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

3.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 1000.0 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 37 785 000 ширхэг энгийн хувьцаатай. Үүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг гагцхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

3.2. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах ба энэ тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргана.

3.3. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу бусад үнэт цаас гаргаж болно.

3.4. Хувьцаа нэмж гаргах замаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж болно.

3.5. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ

4.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

4.2. Ногдол ашиг хуваарилах асуудлыг Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ТАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

5.1. Компанийн удирдлага нь дараах бүтэцтэй байна:

5.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал;

5.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл;

5.1.3. Гүйцэтгэх захирал

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

6.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн /4/ сарын дотор төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зарлан хуралдуулна.

6.3. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлөөс Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээний асуудлыг шийдвэрлүүлэхээр энэ дүрмийн 1.4-т заасан этгээдэд хэдийд ч хандаж болно.

6.4. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:

6.4.1. хурал хуралдуулах газар, өдөр, цаг;

6.4.2. хурлын хэлэлцэх асуудал;

6.4.3. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

6.4.4. хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;

6.4.5. хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;

6.4.6. саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга;

6.4.7. саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;

6.4.8. хурлын дарга;

6.4.9. тооллогын комиссын дарга, гишүүд.

6.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

6.6. Компани хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.

6.7. Хурлын зард дараах зүйлийг тусгана:

6.7.1. компанийн оноосон нэр, байршил,

6.7.2. хурал хийх өдөр, цаг, газар,

6.7.3. бүртгэлийн өдөр

6.7.4. хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам

6.8. Ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчид дараах мэдээллийг танилцуулна:

6.8.1. Санхүүгийн жилийн тайлан;

6.8.2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;

6.8.3. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд;

6.8.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай

- танилцуулга, дүгнэлт;
- 6.8.5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
- 6.8.6. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал;
- 6.8.7. бизнесийн үйл ажиллагааны тайлан.

6.9. Ээлжит бус хурлыг дараах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл хуралдуулна:

- 6.9.1. төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн талаас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- 6.9.2. төлөөлөн удирдах зөвлөлийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрхтэй хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- 6.9.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
- 6.9.4. компанийн өр нь өөрийн хөрөнгөөс хоёр жил дараалан илүү болж, хасах утгатай болсон;
- 6.9.5. төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
- 6.9.6. аудитын хорооноос ээлжит бус хурал хийхийг шаардсан.

6.10. Дараах асуудлыг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

- 6.10.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;
- 6.10.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон тусгаарлах хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
- 6.10.3. компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 6.10.4. компанийн өрийг хувьцаагаар солих;
- 6.10.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 6.10.6. хувьцааг хуваах, нэгтгэх;
- 6.10.7. зорилтот түвшинг батлах;
- 6.10.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдний цалин, урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- 6.10.9. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг хууль тогтоомжид заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх;
- 6.10.10. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 6.10.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн ирүүлсэн саналыг үндэслэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 6.10.12. Компанийн тухай хууль болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд;

6.11. Хувьцаа эзэмшигч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн этгээдийн хүрээнд хэлэлцэн шийдвэр гаргана. Хэрэв нэр дэвшүүлсэн этгээдийг шаардлага хангахгүй гэж үзвэл дахин нэр дэвшүүлэх тухай шийдвэр гаргана.

6.12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож, чөлөөлнө.

7.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 (гурав) нь хараат бус гишүүн байна.

7.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хуульд заасан шалгуурыг хангасан байхаас гадна эрх бүхий этгээдээс болон холбогдох журмаар тогтоосон ур чадвар, мэргэшил, боловсрол, ажлын туршлага зэрэг шаардлагыг хангасан байна.

7.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хууль, Засгийн газраас баталсан журмын дагуу сонгон шалгаруулж томилно.

7.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.5.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;
- 7.5.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 7.5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтот түвшинг үндэслэн компанийн бизнес төлөвлөгөөг батлах;
- 7.5.4. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;
- 7.5.5. Компанийн зарласан хувьцааны тоо, хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;
- 7.5.6. Компанийн энгийн хувьцаа болон бусад үнэт цаас гаргах;
- 7.5.7. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 7.5.8. Компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах, эргүүлэн авах шийдвэр гаргах;
- 7.5.9. Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- 7.5.10. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах шийдвэр гаргах;
- 7.5.11. Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;
- 7.5.12. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- 7.5.13. Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

Handwritten signature and red stamp on the right margin.

- 7.5.14. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
- 7.5.15. Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах;
- 7.5.16. Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 7.5.17. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх;

7.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

7.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

7.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд өөрсдийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсэг зурна.

7.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тэмдэглэл, тогтоол нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

7.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын, эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.

7.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.

7.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

7.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна. Энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

7.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

7.14.1. эдийн засаг, санхүү, бизнесийн удирдлага, инженер, хууль, эрх зүйн мэргэжилтэй, эсхүл тухайн салбараар мэргэшсэн байх;

7.14.2. сүүлийн гурваас доошгүй жил тухайн компанийн толгой болон охин, хараат компанийн эрх бүхий албан тушаал болон зөвлөх, хүний нөөц, шагнал, урамшуулал хариуцсан ажилтнаар ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй, мөн өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллаж байгаагүй, бизнесийн хэлхээ холбоогүй байх;

7.14.3. тухайн компанийн толгой болон охин, хараат компанитай нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд /зээлдүүлэгч, хувь нийлүүлэгчид, хувьцааны багцыг эзэмшигч, хамтран



ажиллагсад г.м/-ын ашиг сонирхлыг төлөөлдөггүй байхаас гадна бизнесийн аливаа холбоогүй байх;

7.14.4. тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд, төрөл, садангийн холбоогүй байх;

7.14.5. компанийн томоохон харилцагчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш байх. /Нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активын 10-аас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/

7.14.6. нэр дэвшигч өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлд бие дааж нэр дэвшүүлэх эрх олгохуйц хувьцааны багцыг эзэмшдэггүй байх.

7.15. Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй:

7.15.1. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

7.15.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

7.15.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх;

7.15.4. төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийх талаар санал боловсруулах;

7.13.5. гүйцэтгэх удирдлагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавих.

7.16. Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороог заавал байгуулан ажиллуулна.

7.17. Хороодын гишүүд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний 2/3 нь хараат бус гишүүн байна.

7.18. Хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.

7.19. Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

7.19.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

7.19.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

7.19.3. аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/;

7.19.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

7.19.5. компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

7.19.6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

17.20 Нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

7.20.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

7.20.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд энэхүү дүрмийн 7.12-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.20.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

7.20.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.20.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

7.20.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

7.20.7. Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах;

7.20.8. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.21. Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

7.21.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

7.21.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

7.21.3. Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн

урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
7.21.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.22. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

7.23. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу ажиллах бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

7.24. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

НАЙМ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон түүнтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

8.2. Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөл томилж, чөлөөлнө.

8.3. Гүйцэтгэх захирал нь хуульд заасан шалгуурыг хангасан байх бөгөөд гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулж, сонгоно.

8.4. Гүйцэтгэх захиралд тавигдах мэргэжил, мэргэшил, ажлын туршлага, ур чадварын шалгуур болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг хууль, журамд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж мөрдүүлнэ.

8.5. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

8.6. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.7. Гүйцэтгэх захирал нь ерөнхий нягтлан бодогч, салбарын захирлыг томилох, чөлөөлөх, асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

8.8. Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

8.9. Гүйцэтгэх захирал нь дараах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан байна.

8.9.1. Монгол Улсын иргэн байх;

8.9.2. Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;

8.9.3. Сэтгэцийн өвчин, эмгэггүй;

8.9.4. 2-оос доошгүй гадаад хэлний ярианы болон бичгийн ур чадвар дундаас дээш түвшинтэй байх;

8.9.5. Автозамын салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй, салбар, нэгжийн удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан, менежментийн ур чадвартай байх;

8.9.6. төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг санаачилж, гардан гүйцэтгэж байсан, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийг хослуулан удирдах судалгаа, эрдэм шинжилгээний ажлын дадлага туршлагатай байх;

8.9.7. зээлийн болон батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

8.9.8. ёс зүйн болон биенесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

8.10. Гүйцэтгэх захирал нь компанийг үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, бизнесийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажиллана.

8.11. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

8.11.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцах, жилд 2-оос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

8.11.2. компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдэд тайлагнаж мэдээлэх, түүнийг үнэн зөвийг хариуцах;

8.11.3. компанийн тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, энэхүү дүрэмд заасны дагуу батлуулах, бизнесийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

8.11.4. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

8.11.5. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

8.11.6. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

8.11.7. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

8.11.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас чөлөөлөх;

8.11.9. Орон нутаг дахь салбаруудын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

8.11.10. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

8.11.11. Компанийн үйл ажиллагааны дотоод журмыг баталж мөрдүүлэх;

8.11.12. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

8.11.13. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг зохих хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

8.12. Гүйцэтгэх захирал нь бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахыг хориглоно.

8.13. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр Компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ЕС. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

9.1. Компанийн тухай хуулийн 84.1-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, салбар, нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэмд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг компанитай байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд байгуулсан гэрээ, тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

АРАВ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

10.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

10.1.1. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хяналт;

10.1.2. Дотоод аудитор;

10.1.3. Хөндлөнгийн аудит;

10.2. Хувьцаа эзэмшигчийн эрхийн хэрэгжүүлэгчийн хяналтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлнэ.

10.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

10.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь компанийн удирдлага, зохион байгуулалт, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа холбогдох хууль болон энэхүү дүрмээр олгогдсон эрхийг эдэлнэ.

10.5. Компанийн хөндлөнгийн аудитыг Үндэсний аудитын газраас сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ.

10.6. Хөндлөнгийн аудитын тайланг ТУЗ-өөр хэлэлцүүлж, дүгнэлтийг Зам, тээврийн хөгжлийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулна.

10.7. Дотоод хяналтыг компанийн дотоод хяналтын нэгж, албан тушаалтан хэрэгжүүлнэ.

10.8. Дотоод хяналт хариуцсан нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн чиглэлийн мэргэжилтэй, ажлын дадлага, туршлагатай ажилнуудаас бүрдэх бөгөөд гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

10.9. Дотоод хяналтын нэгж нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захиралд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.

АРВАН НЭГ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

11.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 5 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 11.1, 11.2-т заасан хэлцлийн талаархи мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

11.4. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтгэйгээр гаргана.

11.5. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд

оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

12.1 Компани нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулах бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

12.2 Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Хувьцаа эзэмшигчид болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдэд танилцуулна.

12.3. Компанийн санхүүгийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ээс эхэлж 12 дугаар сарын 31-нээр дуусна.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

13.1. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

13.2. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

- 13.2.1. Баланс;
- 13.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;
- 13.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан;
- 13.2.4. Хуримтлагдсан ашиг;
- 13.2.5. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
- 13.2.6. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;
- 13.2.7. Нэмэлт тайлбар, тодруулга;
- 13.2.8. Санхүүгийн тайлангийн тодруулга;
- 13.2.9. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, урамшууллын дүн, албан тушаалтан нэг бүрээр гаргах;
- 13.2.10. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

13.3. Санхүүгийн тайланг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар санхүүгийн тайланг хэлэлцүүлнэ.

АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

14.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

14.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

14.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг;

14.1.3. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

14.1.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй бусад гэрээ, түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;

14.1.5. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ;

14.1.6. Аудитын дүгнэлт;

14.1.7. Хувьцаа болон үнэт цаас гаргах журам;

14.1.8. Эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилчдад олгосон цалин, урамшуулал, шагнальтай холбоотой бичиг баримт;

14.1.9. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

14.1.10. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

14.1.11. Бусад баримт бичиг.

14.2. Компани нь өөрийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатай хадгалах, баримт бичгийн хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

14.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг архив, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

14.4. Коампанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

АРВАН ТАВ. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

15.1. Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.

15.2. Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

АРВАН ЗУРГАА. БУСАД

16.1. Компани нь ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор компани, салбарын үйл ажиллагааны зорилго, чиглэл, дүрэм, бүтэц, зохион байгуулалт, хувь оролцоо, санхүүгийн тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэрийн талаар болон хууль тогтоомжид заасан шаардлагатай мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.

16.2. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

16.3. Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн

найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.

16.4. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь эрхи бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

---ooOoo---